



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 31 өдөр

Дугаар A/175

Улаанбаатар хот

Г
Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.14, 12.15 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь;

1. “Удирдах ажилтан, багшийг шилжүүлэн ажиллуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир), хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга наарт тус тус даалгасугай.
3. Хавсралтаар баталсан журмын хүрээнд шилжин ажиллаж байгаа багшийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг тухайн ажиллаж байгаа байгууллагаас олгох асуудлыг төсвийн сар, улирлын хуваарьт зохицуулалт хийх замаар шийдвэрлэж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Б.Батцэцэг)-т даалгасугай.
4. Хавсралтаар баталсан журамд заасан шилжин ажиллах гэрээнд заасан зардлыг хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлж, жил бурийн улсын төсөвт тусгаж санхүүжүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга (Х.Батжаргал)-д даалгасугай.
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд 2 жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Н.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

САЙД

П.НАРАНБАЯР



14241 0528



УДИРДАХ АЖИЛТАН, БАГШИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

АТА12937 9116621 9024070582

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь аймгийн төв, нийслэлийн дүүргийн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн удирдах ажилтан, багшийг адил чанарын ажилд шилжүүлэн ажиллуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Удирдах ажилтан, багшийг шилжүүлэн ажиллуулахад Боловсролын ерөнхий хуулийн 12.14-т заасныг баримтална.

1.3. Шилжүүлэн ажиллуулах хугацаа 1-3 жил байна.

1.4. Удирдах ажилтан, багшийг өөр боловсролын сургалтын байгууллагын адил чанарын ажилд шилжүүлэн ажиллуулна.

1.5. Удирдах ажилтан, багшийг энэ журмын 1.4-т заасан ажил, чиг үүргээс өөр ажил гүйцэтгүүлэхгүй.

Хоёр. Удирдах ажилтан, багшийг шилжүүлэн ажиллуулах нөхцөл, шаардлага

2.1. Журмын 1.1-д заасан боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтантай томилох эрх бүхий этгээд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр шилжүүлэн ажиллуулж болно.

2.2. Журмын 1.1-д заасан боловсролын сургалтын байгууллагын багшийг өөрийн хүсэлтээр томилох эрх бүхий этгээдтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр шилжүүлэн ажиллуулж болно.

2.3. Энэ журмын 2.1, 2.2-т заасан удирдах ажилтан, багшийг дор дурдсан шаардлагад үндэслэн шилжүүлэн ажиллуулна:

2.3.1. тухайн албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан туршлага;

2.3.2. сургалтын байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүн.

2.4. Шилжүүлэн ажиллуулахтай холбоотой шийдвэрийг томилох эрх бүхий этгээд хууль тогтоомж болон энэхүү журамд нийцүүлэн гаргана.

2.5. Удирдах ажилтан, багшийг дараах тохиолдолд шилжүүлэн ажиллуулахгүй:

2.5.1. ээлжийн амралттай;

2.5.2. холбогдох хуульд заасан чөлөөтэй;

2.5.3. жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй;

2.5.4. тэтгэвэр тогтоолгох насанд хүрэхэд гурван жил дутуу;

2.5.5. ёс зүйн болон хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргаж, хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байгаа;

2.5.6. эмнэлгийн урт хугацааны тусlamж, үйлчилгээ авах шаардлагатай;

2.5.7. хууль, журамд заасан бусад тохиолдол.

2.6. Удирдах ажилтан, багшийг шилжүүлэн ажиллуулах тохиолдолд цалин хөлс, нийгмийн баталгаа, хөдөлмөрийн нөхцөлийг дордуулахгүйгээр хүлээх эрх үүрэг, хариуцлага, байршил өөрчлөгдсөнтэй холбоотой зайлшгүй гарах зардал зэрэг асуудлаар энэхүү журмын 1.3-т заасан хугацаагаар талууд харилцан тохиролцож гэрээ байгуулна.

Гурав. Бусад зүйл

3.1. Боловсролын ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон энэхүү журамд зааснаас бусад үндэслэлээр удирдах ажилтан, багшийг өөр ажил, албан тушаалд шилжүүлэн ажиллуулахгүй.

3.2. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн, томилох эрх бүхий албан тушаалтан солигдсон нь шилжүүлэн ажиллуулах шийдвэрийг хугацаанаас нь өмнө цүцлах, шилжүүлэн ажиллуулах хугацаа дууссан удирдах ажилтан, багшийг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулахаас татгалзах үндэслэл болохгүй.

3.3. Удирдах ажилтан, багш шилжин ажиллах хугацаанд шилжүүлсэн байгууллагад бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөний улмаас тухайн албан тушаалын орон too хасагдсан бол тухайн байгууллага нь урьд эрхэлж байсан албан тушаалтай нь адил чанарын өөр ажлын байраар хангана.

3.4. Удирдах ажилтан, багшийг шилжин ажиллахаас татгалзсан үндэслэлээр сахилгын шийтгэл хүлээлгэхгүй.

3.5. Шилжин ажиллах удирдах ажилтан, багшийг шилжин ажиллах хугацаанд албан тушаалд түр томилохгүй.

3.6. Шилжүүлэн ажиллуулах гэрээгээр ажиллаж байгаа багш, удирдах ажилтан тухайн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрмийг мөрдөн ажиллана.

3.7. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь шилжүүлэн ажиллуулах багш, удирдах ажилтны энэхүү журмын 2.6-д заасан гэрээг үнэлж, дүгнэнэ.

3.9. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь энэхүү журмын 3.7-д заасан үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн удирдах ажилтан, багшийг урамшуулах эсвэл Хөдөлмөрийн тухай хуульд заасан арга хэмжээ авна.

3.11. Шилжин ажилласан багш, удирдах ажилтны албан үүргийг хууль тогтоомжид нийцүүлэн чиг үүрэг нь хамгийн ойр хамааралтай ажилтнаар батлагдсан төсөвтөө багтаан орлон гүйцэтгүүлж болно.

--- оОо ---